



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ,
УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЧИЙН
ЭВЛӨЛИЙН ХОЛБОО



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭР




Улаанбаатар хот
2023 он

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжид
нийцэж байгаа тул 2023 оны 06. сарын 01.-ны өдөр буртгэв.

Улаанбаатар хот
2023 он



**ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН
2023-2024 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР**

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 34 дүгээр зүйлийн 34.1.2, 35 дугаар зүйлийн 35.2, 36 дугаар зүйлийн 36.1.2, 107 дугаар зүйлийн 107.5 дах заалтууд, Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ОУХБ-н 176-р конвенцыг тус тус үндэслэн энэхүү хамтын хэлэлцээрийг байгуулж байна.


Хэлэлцээрийн зорилго нь: МЭХГҮҮ-н ҮЭ-ийн холбооны гишүүн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэр харгалзахгүй геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын /цаашид салбарын гэх/ хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэх, үйлдвэрлэлийн үр ашиг, салбарын тогтвортой байдлыг хангахад оршино.

Нэг. Ерөнхий зүйл

- Хууль тогтоомж, геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хамтын хэлэлцээрийг үндэслэн өмчийн хэлбэр харгалзахгүй аж ахуйн нэгж, байгууллагууд хамтын гэрээ байгуулан Хөдөлмөрийн тухай хуулийн 32.1-т заасны дагуу холбогдох газарт бүртгүүлэн мөрдөж ажиллана.
- Хэлэлцээрийн биелэлт, явц, үр дүнд хэлэлцээр байгуулагч талууд хамтран хяналт тавина.
- Хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэх эдийн засгийн үндэс нь ажил олгогчдын санхүүгийн чадавх болох тул салбарын аж ахуйн нэгжүүдийн орлого, ашгаа нэмэгдүүлэхэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, салбарын агентлагууд, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо, мэргэжлийн холбоод хуулийн хүрээнд бодлого, шийдвэрээрээ дэмжинэ.

Хоёр. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийн талаар

- Ажилтнуудыг бөөнөөр халах болон шилжүүлэх тохиолдолд аж ахуй нэгж, байгууллага /ажил олгогч/ нь 45 хоногийн өмнө холбогдох





- Уйлдвэрчний эвлэлийн байгууллагад урьдчилан мэдэгдэж, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, ниймийн хамгааллын талаар тусгай гэрээ байгуулж, орон нутгийн хөдөлмөр зохицуулалтын албанад бичгээр мэдэгдэнэ. Тэтгэмжийн хэмжээг ҮЭ-ийн хороотой хэлэлцэн тогтоох бөгөөд хуульд зааснаас доогуур тогтоож болохгүй. Төрийн болон гэрээт компанийд ажилласан жилийг тооцходо үндсэн салбарт ажилласнаар тооцно.
- 2.2 Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгджэг байгаа хууль тогтоомжийн дагуу салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг өөрчлөн насны тэтгэвэрт гарсан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас групп тогтоолгосон ажилтнуудын ниймийн хамгааллын асуудлыг эрх залгамжилж авсан хуулийн этгээд хариуцаа.
- 2.3 Салбарын төрийн байгууллагад болон салбарын аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан хугацааг тус салбарт ажилласанд тооцно. /Орон тооны ҮЭ-ийн хороодын дарга, нарийн бичгийн дарга нарт нэг адил хамаарах бөгөөд тухайн ААН байгууллагаас сар бүр үргүйн урамшуулалт олгоно/
- 2.4 Үйлдвэрлэлийн осол, хүрц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон өндер насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг тэдний мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг ашиглах зорилгоор өөрийнх нь эрүүл мэндэд харшахгүй ажлын байраар хангах талаарах ажил олгогч санаачилга гаргаж болно.
- 2.5 Геологи, уул уурхай, хунд үйлдвэрийн салбар хөгжих хууль эрх зүй, бизнесийн орчныг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.
- 2.6 Геологи, уул уурхай, хунд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компани, аж ахуйн нэгжүүдийг ажлын байрны мэдээллийн нэгдсэн сантай болох ажлыг хамтран зохион байгууна.
- 2.7 Уул уурхай, хунд үйлдвэрийн салбарт шинэ технологи, инновацийн нэвтрүүлэх замаар Монгол Улсад өндер технологийн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, энэ салбарт хөдөлмөр эрхлэлтийн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллах бөгөөд ажиллагдын эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэхэд талууд дэмжлэг үзүүлж хамтран ажилана.
- 2.8 Хөрөнгө оруулалт технологийн өндер шалгүүртэй геологи, уул уурхай, хунд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн компани, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчлах, дэмжих, борлуулалтын зах зээлийг хамгаалах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр тодорхой ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.

- 2.9 Геологи, уул уурхай, хунд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг "Эх оронч" худалдан авалтаар дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар ажлын байрыг ерөжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.
- 2.10 Аж ахуйн нэгж бүр Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлж ажиллах бөгөөд "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 2.11 Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь залуучууд, эмзгэгчүүд, ахмадуудад чиглэсэн бодлого явуулж жөндөрийн тэгш оролцоо хангаж, дарамт хүчирхийлэлгүй орчинг бүрдүүлнэ.

Гурав. Цалин хөлсний талаар


- 3.1 Цалин хөлсийг жил бүрийн инфляциын тувшин, үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж, хэрэглээний ба үйлдвэрлэлийн үнэ зэргийг харгалзан үндсэн цалинг нэмэгдүүлэх асуудлыг аж ахуйн нэгж байгууллагууд хамтын гэрээгээр зохицуулна.
- 3.2 Геологи, уул уурхай, хунд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндсний хороонос тогтоосон улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.
- 3.3 Ажилтанд ажлын жил бүр эзлэхийн амралт олгох биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар эзлэхийн амралтадаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох эзлэхийн амралтын цалинг хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.
- 3.4 Ажил мэргэжил хавсрлан, хослон, орлон ажилласны нэмэгдлийг хавсрлан, хослон, орлон ажилласан албан тушаалын цалингийн 30-аас дээш хувираа бодож олгоно.
- 3.5 Уул уурхай, хунд үйлдвэрийн яам, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооноос хамтран олгох байгаа "Тэргүүний мастер" дол тэмдгийн дагалдах мөнгөн шагнал 100,000 төгрөгийг тухайн байгууллага олгоно.
- 3.6 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сүл зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлээгүй бол сүл зогсолтын олговор нь уг ажилтны үндсэн цалингийн 60 хувиас доошгүй байна.
- 3.7 Байгууллагын жилийн ажлын үр дүнг харгалзан жилд нэг удаа үндсэн цалингаар тооцож б хүртэл сарын цалинтай тэнцэх жилийн үр дүнгийн нэмэгдлийг олгох асуудлыг хамтын гэрээгээр тохиролцно.



- 3.8 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтээ арга барилаар өндөр ур чадвар гарган хамтын гэрээгээр шийдвэрлэнэ.
- 3.9 Сарын үр дунгийн нэмэгдлийг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 3.10 Оновчтой санал, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх замаар зардал хэмнэсэн тохиолдолд олгох шагналын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 3.11 Салбарт болон байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа ажилтанд удаан жил ажилласны нэмэгдлийг ажилласан хугацаанаас нь хамааруулан хамтын гэрээнд тусгаж олгоно.
- 3.12 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад нөхцөлийн нэмэгдлийг хамтын гэрээгээр зохицуулна.


Дөрөв. Ажилтнуудын мэргэжил, боловсролын талаар

- 4.1 Захиргаа нь Үйлдвэрчний эвлэлийн байгууллагаа зохион байгуулж байгаа сургалт, семинар болон бусад үйл ажиллагаанд ажилтнуудыг хамрагдах бололцоогоор хангах ба тус арга хэмжээнүүдийг үйлдвэрчний эвлэл нь компанийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар зохион байгуулна.
- 4.2 Ажил олгог нь ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна.
- 4.3 Салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулж, шинэ арга барил, ажлын туршилага, мэдээлэл солилцуулах арга хэмжээ авна.
- 4.4 Салбарын хэмжээнд хийгдэх байгаа техник, технологийн шинэчлэлт, хүний нөөцийн бодлогын дагуу ажилтнуудын мэргэжил, боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад ажил олгогчийн санаачилгаар суралцсан ажилтанд сургалтын хугацаанд албан тушаалын холбогдох цалинг олгоно.
- 4.5 Салбарын улсын зөвлөгөөнийг 2 жил тутамд талууд харилцан тохиолцож зохион байгуули болно.
- 4.6 Салбартай эрдмийн зэрэг горилж байгаа, бие даан судалгаа шинжилгээний ажил хийж буй ажилтныг ажил олгогчийн зүгээс боломжит бүхий л нөхцөлөөр дэмжих тухай хамтын гэрээнд тусган хэрэгжүүлнэ.



Тав. Нийгмийн асуудлын талаар
доходлон хотуудын булагчийн санхүүхэд хөгжлийн талын нийтийн
нэгжийн төслийн талаар

- 5.1 Ажилтнуудад хоол, унааны хөнгөлөлтийг хамтын гэрээгээр тохиолцон олгоно.
- 5.2 Төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй суурин амьдардаг ажилтанд тухайн хилийн халаалтын улирлын хөнгөлөлт олгох асуудлыг хамтын гэрээгээр зохицуулна. /Энэ заалт ахмадууд, Үйлдвэрэлэйн осол, Мэргэжлээс шалтгаалах евчиний групптэй хумүүст нэг адил хамаарна./
- 5.3 Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үүднээс рашаан сувиллын сувилуулсны зэрдлыг магадлан итгэмжлэгдсэн рашаан сувиллын илгээх бичгийг үндэслэн жилд 1 удаа 50 хувиар хөнгөлнө. /Энэ заалт ахмадууд, Үйлдвэрэлэйн осол, Мэргэжлээс шалтгаалах евчиний групптэй хумүүст нэг адил хамаарна./
- 5.4 Салбарт ажиллаж байгаад өндөр насын тэтгэвэр тогтоолгосон ажилтанд салбарын хөдөлмөрийн хөлслний доод хэмжээг 2 дахин намзгдуулсэнтэй танцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг салбарт ажилласан жилээр үргүүлэн тооцож олгоно.
- 5.5 Салбарын тэмдэглэлт ойг тохиолдуулан "Ажилтнуудын урлаг, спортын наадам"-ыг зохион байгуулах эсэхийг талууд харилцан тохиолцно.
- 5.6 Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлд өртж орон гэргүй болсон, эд хөрөнгийн хохирол учирсан ажилтанд хохирлын хэмжээг харгалзан үзэж нэг удаагийн буцалтгүй тусламжийг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.7 Байгуулагын хөдөлмөрийн аварга, хүндэт дэвтэрт бичигдсэн ажилтан, ажил мэргэжлийн аваргыг шагнах шагналын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.8 Салбарын тэргүүний ажилтны нэмэгдэл урамшууллыг сар бүр 10.000 төгрөгөөс доошгүйгээр тогтоож тус салбарт ажиллаж байгаа бусад салбарын тэргүүний ажилтан, гавьяат ажилтан, төрийн шагналтан, хөдөлмөрийн баатарт олгох нэмэгдэл урамшууллын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.9 Монгол Улсын төрийн дээд шагнал /Төрийн соёрхолт, Гавьяат ажилтан, Хөдөлмөрийн баатар/-аар шагнагдсан салбарын ажилтан, өндөр настанд тухайн ажиллаж байгаа болон харьялагдах байгууллагаас нэг удаагийн мөнгөн урамшуулалт олгох асуудлыг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.




- 5.10 Ажилтны эцэг эх, эхнэр нөхөр, хүүхэд нас барж уй гашуу тохиолдоход үзүүлэх мэнгэн тусламжийн хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.11 Ажилтан болон ахмадуудаас ирсэн өргөгдлийг үндэслэн тухайн өрхийн нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны баталгаважин доод тувшинд хүрэхгүй, З хүртэл насын хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүд, тухайн байгууллагаас өндөр насын тэтгэвэрт гарсан ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчиний улмаас нас барсан хүний ар гэрт, мөн эрх толгойлон эхчүүд, эрчүүд, бүтэн өнчин үлдсэн айлын нэг хүүхэд үзүүлэх мэнгэн тусламжийн хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.12 Ажилтан нас барсан тохиолдолд ар гэрт нь 6 сараас дээш үндсэн цалинтай тэнцэх буцалтгүй тусламжийг нэг удаа олгоно.
- 5.13 Харьяа аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаад өндөр насын тэтгэвэрт гарсан ахмадууд, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчиний групптэй хүмүүс нас барсан тохиолдолд опгох буцалтгүй тусламжийн хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.14 Байгууллагын нэрийн өмнөөс олон улс, улс, хотын чанартай спорт, урлаг, уран сайхны тэмцэн, уралдаанд оролцсон ажилт гаргасан ажилтны шагнал урамшууллын хэмжээг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.15 Орон сууц авах гэж байгаа ажилтанд тухайн байгууллага нөөц боломждоо тулгуурлан дэмжлэг үзүүлж болно.
- 5.16 Салбарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр орон тоог цомхотгох, ажлын байрыг цөөрүүлэх, хувьчлагдах тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор өмчийн хэлбэр үл харгалзан уг ажилтанд албан тушаалын болон үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг хамтын гэрээндээ тусган хэрэгжүүлнэ.
- 5.16.1 3-4 жил ажилласан бол 1-4 сарын
5.16.2 5-10 жил ажилласан бол 6 хүртэл сар
5.16.3 11-15 жил ажилласан бол 12 хүртэл сар
5.16.4 16 ба түүнээс дээш жил ажилласан бол 24 хүртэл сар

Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар


- 6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг үлгэр жишээ зохион байгуулсан аж ахуйн нэгж байгууллагыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний хорооноос

— 11 —




- Олгодог "Эрүүл аюулгүй байдлыг эрхэмлэг байгууллага"-аар шалгарахад талууд дэмжлэг үзүүлнэ.
- 6.2 Ажил олгогч ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийгэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг бууруулах арга хэмжээг авна.
- 6.3 Аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо ISO-45001 стандарт болон нийгмийн хариуцлагын стандартыг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах ажлыг талууд хамтран хэрэгжүүлнэ.
- 6.4 Ажил олгогч нь гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд даатгуулна.
- 6.5 Жил бурийн 4 дүгээр сарын 28-нд үйлдвэрлэлийн ослоор амь эрсдэсэн хүмүүст хундэтгэл үзүүлэх едрийг тохиолдуулан ХАБЭА-н сарын аяныг салбарын хэмжээнд талууд хамтран зохион байгуулна.
- 6.6 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд талууд хамтран зохион байгуулах ажиллах, салбарын ХАБЭА-н асуудлаар санал дүгнэлт гаргах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчьеөс урьдчилан сэргийлэх, гарсан осол, гэмтлийн талаарх мэдээллийг солилцох, аж ахуйн нэгжүүдэд мэргэшсэл аргазын зөвлөмж өгч ажиллана.
- 6.7 Монгол Улсын стандартын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг шинэчлэн тогтоо шаардлагатай ажлын байрны жагсаалтыг хамтран гаргаж Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 6.8 Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 176-р конвенц, ХАБЭА-ын тухай ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 155-р конвенцыг хэрэгжүүлэх ажлыг талууд хамтран зохион байгуулж хэрэгжилтэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Монголын эрчим хүч, геологи уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо хамтран хяналт тавина.
- Долоо. Үйлдвэрчний эвлэлийн эрхийг хангах талаар**
- 7.1 Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Монгол Улсын соёрхон баталсан ОУХБ-н конвенцуудыг хэрэгжүүлнэ. Үүнд нь:
1. Аж ахуйн нэгж байгууллага нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шаардлагах эдийн засаг, санхүү, үйл ажиллагааны мэдээллийг ҮЭ-д өгнө.
 2. Ажил олгогч нь ажилтны бичгээр гаргасан зөвшөөрлийг үндэслэн гишүүний татварыг цалингаас сар бүр бэлэн бусаар хурааж, ҮЭ-ийн хорооны дансанд шилжүүлнэ.

— 12 —



3. ҮЭ-ийг үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах өрөө тасалгаа, техник хэрэгслийр хангана.
 4. Хамтын гэрээ байгуулахдаа хүрсэн түвшингээс нь бууруулахгүй байх зарчим баримтална.
- 7.2 Үйлдвэрчний эвлэл нь дараах үйл ажиллагааг ажлын цагаар зохион байгуулахад ажил олгогч нехцел боломжоор хангах ба Үйлдвэрчний эвлэл нь онцгой ажлын байруудад (Төсрөх материалын агуулах, химийн бодисын агуулах, харуул хамгаалалтын болон бусад тусгай объектүүд) ажиллаж буй ажилтнуудыг хамруулахыг хориглоно.
1. Хамтын гэрээ, хэлэлцэр хийх, батлах, явац үр дүнг хэлэлцэх
 2. Хамтын гэрээ, хэлэлцээр тусгагдсан хичээл, семинар, зөвлөгөөн хийх
 3. Үйлдвэрчний байгууллагад тавьсан аливаа санал гомдлыг авч хэлэлцэх
 4. Үйлдвэрчний эвлэлийн бүх гишүүдийн хурал хийх
 5. Ажил олгогчтой тохиролцсоны дагуу зохион байгуулах бусад арга хэмжээнүүд
- 7.3 Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульт ажилтныг байгууллагын үндсэн ажилтны адил хамтын гэрэнд хамруулж, гарах зардлыг ажил олгогч бүрэн хариуцна.
- Нийм. Хэлэлцээрийн хэрэгжилтийн талаар**
- 8.1 Хэлэлцээр нь талууд гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн 2 жилийн хугацаанд хүчинтэй. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр цалин хөлс болон бусад асуудлаар хэлэлцээр нэизэлт өөрчлөлтөр оруулж болно.
 - 8.2 Талууд салбарын хамтын хэлэлцээрийн биелэлтийн явцыг жил бүр хамтран дүгнэж, хянайлт тавьж ажиллана.
 - 8.3 Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, эмчилэлийн харьяалалд өөрчлөлт орох нь энэхүү хамтын хэлэлцээрээр тохирсон асуудлыг цуцлах үндэслэл болохгүй.
 - 8.4 Хэлэлцээрээр хүлээсэн үүрэг зөрчигдсөн тохиолдолд аль нэг тал маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд төлөөлгөчдийн хуралдааныг 7 хоногийн дотор зарлан хуралдуулах эрхтэй.
 - 8.5 Хэлэлцээрээр харилцан дүлээсэн үүргээ биелүүлэх явцад талуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс саад учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ.
 - 8.6 Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн маргааныг "Хедэлмэрийн тухай хууль" болон бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯМ

15100 Улаанбаатар хот. Чингисийн дүүрэг,
Нийдээн ундастгийн гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34. Цахим шүудан: msp@mongolnet.mn
Цахим хуудас: www.msp.gov.mn

2023. 06. 22 № 09/1693

УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

Геологи, уул уурхай, хунд үйлдвэрийн
салбарын 2023-2024 хамтын хэлэлцэртэй
танилцаа.

Хедэлмэрийн тухай хуулийн 32 дугаар
зүйлийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу Геологи, уул
уурхай, хунд үйлдвэрийн салбарын 2023-2024
хамтын хэлэлцээрийг 2023 оны 06 дугаар сарын
22-ны өдөр бүртгэсэн болно.

Хэлэлцээрийн хувиудыг хавсаргав.

ХЕДӨЛМЭРИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА *Б. Алимаа*



Ту 3894
9132155
1119277787

ENAO

157231553

D: 2023 on 06 sar A5



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРНИЙ САЙДЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 15 дугаар

Дугаар 11/2022

Улаанбаатар хот

Төлөөлөгчид томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай куулийн 24 дугаар зүйлийн 2 дахь хасэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, 22.6 дахь хасэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1, 14.3.1 дэв замалт, 18 дугаар зүйлийн 18.1 дахь хасэг, 19 дугаар зүйлийн 19.1 дахь хасгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрийг Монголын үрчин хүч, геологи уул уурхайн үйлдвэрийн залэлтүүдийн холбод ажил олгогч үедийн байгууллагатай байгуулах төлөөлөгчдийг дараах бүрэлдхүүнтэй томилсугай.

Түнд:

Төлөөлөгчдийн ахлагч:

Б.Бямбадагва

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Г.Менгэнзул

Төрийн захирагааны удирдлагын газрын ахлах шинжээч

Б.Бямбарагчaa

Хүнд үйлдвэрийн бодлогын газрын Дэд бүтцийн хэлтэсийн ахлах мэргэжилтэн

Б.Цацрал

Геологийн бодлогын газрын Геологийн хэлтсийн мэргэжилтэн

Н.Амартуул

Уул уурхайн бодлогын газрын Техник технологийн хэлтсийн мэргэжилтэн

А.Сайнзаяа

Төрийн захирагааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

М.Анхбаяр

Төрийн захирагааны удирдлагын газрын мэргэжилтэн

2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамт /тарииф-/ын хэлэлцээрийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны дотор байгуулж баталгавжуулалт арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөгчдийн ахлагч /Б.Бямбадагва/-д давалгасугай.

3. Төлөөлөгчдийн бүрэлдхүүний шинэчилсэнтэй холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 17-ны едрийн А/160 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ж.ГАНБААТАР

1508 01 0833
дүүхийн 2022 Сайд Тушаал дос

МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРНИЙ САЙДЫН ТУШААЛ
ААНАГАА ЧАЛЧИЛЧИЛСААСАН НАМНЯАЛСААСАН
ААНАГАА ЧАЛЧИЛЧИЛСААСАН НАМНЯАЛСААСАН



МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Төлөөлөгчдийн бүрэлдхүүний шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн II бүлгийн 13.2, 20.4, 21.1, 34.1.2, 35.2, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны дурмын 5 дугаар бүлэг 18 дугаар зүйл 18.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ Нь:

Нэг. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамт /тарииф-/ын хэлэлцээрийг ҮЭ-ийн холбооноос орох төлөөлөгчдийг дараах 7 хүний бүрэлдхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Төлөөлөгчдийн ахлагч

Д.Долгор

МЭХГҮҮ-Н ҮЭ-ийн холбооны дарга

Төлөөлөгчдийн бүрэлдхүүн

А.Дагвадорж

МЭХГҮҮ-Н ҮЭ-ийн холбооны нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

Д.Золжаргал

"Оюу Толгой" ХХК-ийн ҮЭ-ийн хорооны тэргүүлэгч

Д.Жавхлан

"Багануур" ХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

Ц.Сувдээрэл

"Төмөрлөгийн үйлдвэр" ҮЭ-ийн хорооны дарга

Д.Батболд

"Монголпросцветмет" ТӨҮГ-ЫН ҮЭ-ийн хорооны дарга

С.Биндээрьяа

"Геологийн судалгаа шинжилгээний төв" ТӨҮГ-ЫН ҮЭ-ийн хорооны дарга

Хоёр. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хамт /тарииф-/ын хэлэлцээрийг өмнө хүрсэн түвшингээс бууруулахгүй байгуулахыг төлөөлөгчдэд үүрэг болгосугай.

ХУУЛБАР ҮНЭН.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



А.ДАГВАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД
ЖГАНБААТАР, МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА ДДОЛГОР НАР ТАНАА

2023 оны 03 дугаар
сарын 01-ны өдөр №009

Улаанбаатар хот

ИТГЭМЖЛЭЛ

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн "Хөөрдүгаар бүлэг, Гуравдугаар бүлэг, Дөрөвдүгээр бүлэг"-ийн заалтуудаг тус тус узасдан ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ тухай.

1. Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам, Эрчим хүч, геологи, уул уурхай үйлдвэрийн эвлэлийн холбогдот байгуулах "Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамт /тариф/ ын хэвлэлийр"-т Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ажил олгогч эздинг төлөөлөн оролцож төлөөлгөчдийн дарах бүрэлдэхүүнтэйзэр томинлон итгэмшиж байна. Үнд:

Салбарын төлөөллийн хялагч:

1. Г. Эрдэнзуяа Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал

Гишүүд:

2. Г.Тамир Төлөөлөгч, "Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Улаанбаатар дахь төлөөлгөчийн газрын Захиргаа, аж ахуйн албаны дарга
3. З.Сугармаа Төлөөлөгч, "Энержи ресурс" ХХК-ийн Терийн байгууллагын харилцаа, Зөвшөөрөл хариуцсан захирал
4. Ж.Эрдэнэбүлэг Төлөөлөгч, "Оюу Толгой" ХХК-ийн Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалтын газрын Хөдөлмөрийн харилцааны менежер
5. Ж.Түвшинзаяа Төлөөлөгч, "МоЖико" ХХК-ийн омгоёлгч
6. П.Ариуннаа Төлөөлөгч, "Баян Айраг Эксплорэйши" ХХК-ийн Хүний неөц, захиргааны хэлтсийн менежер
7. Н.Амаржаргал Төлөөлөгч, "Хан Алтай Ресурс" ХХК-ийн Захиргаа, хүний неөц, сургалт хариуцсан захирал

2. Салбарын тарифын хэлэлцэр байгуулах болтгэл ажлыг хангаж Уул уурхай, Хүнд үйлдвэрийн салбарын ажил олгогч, эздини санынг авч иягдсан хэлэлцэрт тусгуулах замвар ажлы олгогч эздини хуулиар олгогдсон эрх ашиг, сонирхол, байр сууриний нэрхийнлж оролцохыг төлөөлгөчийн ахлагч Г.Эрдэнзуяа/-д зөвлөсүгэй.

МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН НЭГДСЭН
ХОЛБООНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ
/Хөдөлмөр, ингээгүй түншлэлийн гурван талт улсын
хэлэлцэрлийн ажил олгогч талын төлөөлгөчийн ахлагч/



УХЗ 0050

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн А/286 тоот тушавалвар эрх олгогдсон төрийн захиргааны төв төрөлжилтийн төслийн төлөөлгөчид:

УУХҮЯН-ны Терийн нарийн бичийн-дарын үүргийг түр орлон гүйцэтгэг,
Терийн захиргааны
удирдлагын газрын дарга

Г.Батбаяр
захиргааны
удирдлагын газрын ахлах
шинжээ

Г.Менгэнзул
захиргааны
удирдлагын газрын Хуулийн
хэлтсийн ахлах маргажилтэн

А.Сайнзаяа А.Сайнзаяа

Геологийн бодлогын газрын
Геологийн судалгаа,
төлөөлгөлийн хэлтсийн
ахлах маргажилтэн

Б.Цацран

Хүнд үйлдвэрийн бодлогын
газрын Дад бүтцийн хэлтсийн
ахлах маргажилтэн

Н.Шинэжаргал

Терийн захиргааны
удирдлагын газрын
маргажилтэн

С.Батсүрэн

Уул уурхайн бодлогын
газрын Техник технологийн
хэлтсийн маргажилтэн

Н.Амартуул

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЗ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 13 тоот тогтоогоор эрх олгогдсон салбарын ажилд төлөөлгөчид:

МЭХГҮҮ-Н ҮЭ-ийн холбооны
дараа

ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АХЛАГЧ

Д.Долгор
Г.Эрдэнзуяа

төлөөлгөчид:

МЭХГҮҮ-Н ҮЭ-ийн холбооны
нарийн бичийн дарга

А.Дагвадорж

"Дарханы темерлэгийн
үйлдвэр" ТӨҮГ-ын ҮЭ-ийн
хорооны дарга

Ц.Сувдэрэл

"Монголпроспектмет" ТӨҮГ-
ын ҮЭ-ийн хорооны дарга

Д.Батболд

"Геологиян судалгаа
шинжилгээний төв" ТӨҮГ-ын
ҮЭ-ийн хорооны дарга

С.Биндээрьяа

"Оюу Толгой" ХХК-ийн ҮЭ-
ийн хорооны дарга

Д.Зонжаргал

"Багануур" ХХК-ийн ҮЭ-ийн
хорооны дарга

Д.Жавхлан

Монголын ажил олгогч
эздиний нэгдсэн холбооны
2023 оны 3 дугаар сарын
31-ний 009 тоот
Итгэмжилээр эрх
олгогдсон Уул уурхай,
хүнд үйлдвэрийн
салбарын ажил олгогч
эздин төлөөлгөчид:

МУУЯА-ийн гүйцэтгэх
захирал

Г.Эрдэнзуяа

"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын
Улаанбаатар дахь төлөөлгөчийн газрын Захиргаа,
Аж ахуйн албаны дарга

Г.Тамир

"Энержи Ресурс" ХХК-ийн
Терийн байгууллагын
харилцаа, Зөвшөөрөл
хариуцсан захирал

З.Сугармаа

"Оюу Толгой" ХХК-ийн БХБЗБ-
ын газрын хөдөлмөрийн
харилцааны менежер

Ж.Эрдэнэбүлэг

"МоЭнг" ХХК-ийн омгоёлгч

Ж.Түвшинзаяа

"Баян Айраг Эксплорэйши" ХХК-
ийн Хүний неөц, захиргааны
хэлтсийн менежер

П.Ариуннаа

"Хан Алтай Ресурс" ХХК-ийн
Захиргаа, хүний неөц, сургалт
хариуцсан захирал

Н.Амаржаргал